БАТЛАВ
УВС АЙМГИЙН САГИЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Г.ЧИНЗОРИГ

БАТЛАВ
“ВЕСТЕРН ХОЛД” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ЭНХБАТ

УВС АЙМГИЙН САГИЛ СУМЫН НУТАГ ДАХЬ “БАРУУН ЦЭРД” НЭРТЭЙ /MV-023054/ ГӨЛТГӨНИЙН ОРДЫН 2026 ОНД ГҮЙЦЭТГЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ХЯНАСАН:

УВС АЙМГИЙН САГИЛ СУМЫН
БО-НЫ ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Б.БАТБОЛД

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

“ВЕСТЕРН ХОЛД”ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕР Б.ДЭЛГЭРМАА

УВС АЙМАГ
2026

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Баруун Цэрд гөлтгөнийн ордын товч танилцуулга

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Талбайн физик газарзүй

2.2. Цаг агаар

2.3. Усан орчин

2.4. Хөрсөн бүрхэвч

2.5. Ургамлын нөмрөг

2.6. Амьтны аймаг

2.7. Нийгэм эдийн засаг

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛТИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1. Агаарын чанарт үзүүлэх болзошгүй нөлөөлөл

3.2. Газрын гадарга, хөрс, ургамлын бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

3.3. Усанд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл

3.4. Амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

3.5. Нийгэм эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Төлөвлөгөөний зорилго, зорилт

ТАВДУГААР БҮЛЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

5.4. Тэрбум мод хөтөлбөрийн төлөвлөгөө

5.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

5.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

5.7. Осол, эрсдлийн менежементтийн төлөвлөгөө

5.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

5.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

5.10. Тухайн жилийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

5.11. Төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах

5.12.”Баруун Цэрд” ордын 2026 оны БОМТ-ний нийт зардал

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төсөл хэрэгжүүлэгч: “Суммус” ХХК

Төслийн нэр: “Баруун цэрд” нэртэй гөлтгөнийн ордыг ил аргаар ашиглах төсөл

Улсын бүртгэлийн дугаар: 9011428029

Регистрийн дугаар: 5736609


Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, бага тойруу 4, 12 тоот.

Талбайн хэмжээ: 571.56

Төслийн байршил: Баруун цэрд гөлтгөнийн орд нь “Суммус” ХХК-ийн эзэмшилд MV-023054 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд байрлах ба Увс аймгийн Сагил сумын нутагт оршино. Уг гөлтгөнийн орд нь Улаанбаатар хотоос баруун хойш 1,550 км-т, Сагил сумын төвөөсөө зүүн хойш 15.3 км орчим зайд Хархираа уулсын зүүн хойд хэсэгт оршино.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн солбицол

№	Уртраг			Өргөрөг		
	градус	Минут	секунд	Градус	минут	секунд
1	91	50	14	50	26	5.5
2	91	50	14	50	25	24
3	91	36	00	50	25	24
4	91	36	00	50	25	41.83
5	91	36	49.16	50	25	41.83
6	91	36	49.16	50	26	5.5



Зураг 1. “Баруунцэрд” нэртэй гөлтгөнийн ордын байршлын зураг

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Талбайн физик газарзүй

Увс аймаг нь Монгол орны баруун хойморт Их нууруудын хотгорын хойд хэсэгт өргөргийн дагуу сунаж тогтсон 69.6 мян.км^2 газар нутагтай. Баруун талаараа 200 км Баян-Өлгий, өмнө талаараа 152 км Ховд аймаг, зүүн талаараа 340 км Завхан аймаг, хойд талаараа 575 км ОХУ-тай тус тус хиллэдэг.

Нийслэл Улаанбаатараас 1400 орчим км алслагдсан. Аймгийн төв Улаангом сум д.т.д 939 метр өндөрт оршдог. Увс, Хяргас нуур түүний эргэн тойрны говийн бүс, Хархираа, Түргэн, Ханхөхийн өндөр уулс бүхий говь, цөлөөс өндөр уулын мөнх цас, мөсөн гол хүртэлх төв Азийн гадагш урсгалгүй ай савын босоо бүслүүрийн бүхий л хэв шинжийг тусгасан ландшафт газарзүйн өвөрмөц тогтоцтой. Нутаг дэвсгэрийн 8.2 %-ийг уулын ойт хээр, 14.5 %-ийг өндөр уулын, 37.7 %-ийг хээрийн, 39.6 %-ийг говь цөлийн бүс эзэлдэг.

2.2. Цаг агаар:

Их нууруудын хотгор, Алтайн салбар уулсын бүсэд орших тул эрс тэс эх газрын уур амьсгалтай. Увс нуурын хотгор нь эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн уулс хоорондын хотгор төдийгүй төв Азийн антициклоны төв юм.

Өвлийн улиралд агаарын даралт 1-р сард 1054 га болж, агаарын температур 1-р сард Зүүнговь, Тэс, Улаангом зэрэг ихэнх сумдад -50С хүрдэг нь монгол оронд тэмдэглэгдсэн хамгийн бага утга тул Увс нуурын хотгорыг Монгол орны хамгийн хүйтэн газар гэж үздэг.

2.3. Усан орчин: Ус зүйн сүлжээний хувьд бараг бүхэлдээ төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтана. Монголдоо томоохонд тооцогддог Увс, Хяргас, Айраг, Ачит, Үүрэг, Баян, Цавдан, Сангийн далай, Дөрөө зэрэг нууруудад нь ховор, ховордсон ан амьтан, давс элбэгтэй, байгалийн үзэсгэлэн төгс, онгон дагшин газар нутагтай билээ.

2.4. Хөрсөн бүрхэвч:

Сагил сум нь хөрсний мужлалын хувьд Хангай-Алтайн экологийн бүс болон Хярганы нурууны мужид багтах ба газар зүйн байршлын хувьд Хярганы нуруу түүнээс тал бүр тийш салбарласан уулс аажим намссаар бэсрэг уулс болон улмаар ухаа гүвээ, талд шилжинэ. Уулт ойт хээрийн, уулын ойн саарал ба уулын хээрийн хүрэн хөрсний бүслүүрт хамаарна. Уулын ар хажууд 1400 метрийн үнэмлэхүй өндөр хүртэл хар хүрэн, хүрэн хөрс 1400-1600 метрт уулын хар шороон хөрс түүнээс дээш өндөр (1800-2200 метр)-т уулын ойн саарал ба уул тайгын ширэгт чандруувтар хөрс тус тус тархаж, уулын хавтгайдуу оройд уулын нугын хүлрэнцэр нимгэн хөрсөөр солигддог байна.

2.5. Ургамлан нөмрөг:

Аймгийн нутагт говь-хээрийн бүс зонхилсон өвс ургамал нөмрөгийн хувьд тачирдуухан боловч төрөл зүйл олон, жимс жимсгэнийн ургамалтай. Хар мод, хус, хуш, нарс, улиас, бургас, улаан харгана, алтан харгана нутгийн ихэнх хэсгээр тархсан. Зүүнговь, Сагил, Түргэн сумын нутгаар мөнх ногоон гацуур модтой. Увс нуурын эрэг орчим, Тэсийн голын адаг орчмоор улиасан төгөл, бургасан шугуй, тэмээн харгана бүхий алаг өвст, үет, нугын бүлгэмдэл зонхилно. Алтангагнуур, вансэмбэрүү, алтан хундага, нохойн хошуу, тарваган шийр, халгай, таван салаа, хунчир зэрэг эмийн ургамалтай.

2.6. Амьтны аймаг:

Тус аймаг 72 зүйлийн хөхтөн, 270 зүйлийн шувуу, 7 зүйлийн загас, 411 зүйлийн ургамалтай. Хан Хөхий, Хархираа, Түргэний уулсаар буга, гахай, аргаль, янгир, ирвэс, шилүүс, хадны суусар, нохой зээх, хээр тал зарим голын хөндий уулархаг нутгаар чоно, үнэг, дорго, тарвага зэрэг зэрлэг ан амьтан амьдардаг. Нууруудад хун, нугас, хотон зэрэг усны шувууд, уул талаар хойлог, тоодог, тас, бүргэд, ёл, Ховд, Бөхмөрөний голд алтан гургалдай зэрэг төрөл бүрийн жигүүртэн шувуудтай. Тэс, Нарийн голын сав нь хүйтэн цуст амьтад амьдардаггүй бүсэд хамаарна. Бөөрөг дэлийн элсний районд хээрийн бүлгэмдэл тархсан. Хонин гүрвэл, говийн гүрвэл, могой гүрвэл, бамбай хоншоорт могой зэрэг мөлхөгчидтэй. Ан агнуурын амьтдаас хярс, мануул, өмхий хүрэн, солонго элбэг бол агнуурын шувуудаас ногтруу, дагуурын ятуу элбэг тархсан.

2.7. Нийгэм эдийн засаг: Баян чандмань уулын аймгийн Төгсбуянт хан уулын хошууны Баянзүрх сум нь одоогийн Сагил сум юм. Үүрэг нуур, Баянзүрх, Боршоо, Өндөр мод, Хар мод гэсэн 5 багийн нийт 600 өрхөд 2300 хүн амьдардаг.Хүн амын тоогоор Увс аймгийн 19 сумаас эхнээсээ 17-д, газар нутгийн хэмжээгээр 7-д ордог, хүн амын нягтралаар 5.49 хүн/га ногддог сум юм.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1.Агаар, агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөө:

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үед тоосжилт үүсэх,
- Уурхайн олборлолтын явцад хөрс хуулалт, хүнд механизмуудын ашиглалт зэргээс үүдэн агаарт дэгдэх тоосжилтын хэмжээ ихсэх, ойр орчмын газарт бохирдсон агаар тархах,
- Уурхайн талбайд ажиллах тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас утаа, хөө тортог, хорт хийнүүд агаарт дэгдэх,
- Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн тоосжилт, хорт хий газарт бууж ургамлын бүрхэвч ба хөрсөнд нөлөөлөх,
- Тэсэлгээний ажлын үед гарах тоосжилтын нөлөө, дуу чимээний нөлөө,
- Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээний нөлөөлөл,
- Хог хаягдлаас үүсэх эвгүй үнэр агаарын орчныг бохирдуулна

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ:

- Замын тэмдэг тэмдэглэгээ хийж мөрдүүлэх,
- Тоос шороо их үүсэх салхи шуургатай, хуурай нөхцөлд тоосны ялгаралтыг багасгах зорилгоор хөрс ачиж буулгах өндрийг багасгах зэрэг арга хэмжээнүүдийг авах,
- Тоосжилтын хяналтыг тоосжилт үүсэх эх үүсвэрүүд болон ажлын байранд тогтмол хийж, ихэссэн үед нь холбогдох арга хэмжээ авч байх,
- Уурхайн олборлолтоос үүсэх овоолгыг зонхилох салхин дор байршуулахаар төлөвлөн ажиллана,
- Уурхайн ажилтнуудад амьсгал хамгаалах хэрэгслийг холбогдох нормд заасны дагуу тогтсон хугацаанд хангаж ажиллана,
- Тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэг, шалгалтад тогтмол оруулж, ялгаруулж буй хорт хийн түвшинд хяналт тавих, засвар үйлчилгээг тогтмол чанартай хийх.

3.2. Газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөө:

- Тээвэрлэлтийн үед олон салаа зам гаргаснаас хөрс элэгдэл эвдрэлд өртөх,
- Машин техникийн олон салаа зам үүсэж талбайн ургамлыг сүйтгэж, хөрсийг халцалж, газрыг элэгдэл эвдрэлд оруулан, тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулах,
- Хүнд даацын машин механизм, түүний тээвэрлэлт, засвар үйлчилгээний улмаас шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах,
- Хог хаягдал уурхайн эргэн тойронд тархсанаас үүдэн орчин бохирдох,
- Тоосжилт үүссэнээс ургамал ба ургамлын бүрхэвч тоосонд дарагдаж, үүнээс шалтгаалан навч гэрлийг шингээх нь буурч ургамлын фотосинтезийн бүтээмж доройтох болно,
- Уурхайн үйл ажиллагааны нөлөө болон олборлолтоос үүдэн ургамал бүр мөсөн устах, талхагдалд өртөх,
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр олон салаа зам бий болсноор ургамлын нөмрөг талхагдалд өртөх,
- Орчны бохирдлын нөлөөгөөр ургамлын нөмрөгийн амьдрах орчныг доройтуулах,
- Хатуу болон шингэн хог хаягдлаар уурхайн орчин бохирдох.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ:

- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалтын MNS 5916:2008 стандартыг хэрэгжүүлэх,
- Хөрсний элэгдэл, эвдрэлээс сэргийлэхийн тулд сөрөг нөлөөлөлд өртсөн хөрсийг тухай бүр сайжруулах, нөхөн сэргээх арга хэмжээ авч байх,
- Олон салаа зам гаргахгүй байх, уурхайн талбай, ажилчдын сууц зэрэг тээвэрлэлтийн үндсэн замын маршрутыг тодорхой тогтоож замыг тэмдэгжүүлэх самбар байрлуулах,
- Замгүй газраар тээврийн хэрэгсэл явж талхагдал үүсгэх гол нөхцөл болдог тул үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд тээврийн хэрэгслүүдийн зорчих замыг нарийн зохион байгуулах,
- Олборлолт дууссаны дараа ашиглагдсан талбайг хэлбэршүүлэх, тэгшлэх, үржил шимт хөрсөөр хучих зэргээр техникийн нөхөн сэргээлт хийх,

3.3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Тус гөлтгөнийн орд нь унд ахуй, зам усалгаа, ногоон байгууламжийн усалгааг уурхайн талбайд байрлах гүний худгийн усыг ашиглах учраас гүний усны нөөцийн хомсдол үүснэ,
- Уурхайн талбайд ахуйн бохир усыг ил задгай асгаснаас үүдэн орчны бохирдол үүсэх.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ:

- Ахуйн хэрэглээний усыг бохир ус цэвэршүүлэх байгууламжаар дамжуулан стандартын шаардлагын дагуу цэвэршүүлж тоос дарах, зүлэг мод услахад эргүүлэн ашиглах,
- Бие засах газар түүний орчны хөрсийг эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагын зөвлөмжийн дагуу тогтмол ариутгал халдваргүйжүүлж байх,
- Үер усны ус уурхайд орохоос сэргийлсэн суваг шуудуу, далан хаалтыг байгуулах,
- Ажилчдын суурин болон үйлдвэрлэлийн явцаас гарсан хог хаягдал, түүнчлэн

нефть бүтээгдэхүүний хаягдал хур бороо, хаврын шар усны үерт урсан, орчныг бохирдуулахаас сэргийлж хог хаягдлыг байнга цэвэрлэж тусгай саванд хуримтлуулж, тээвэрлүүлэх,

- Хөрсөнд асгарсан ШТМ асгарсан тохиолдолд нэн даруй саармагжуулах.

3.4. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөлөл:

- Олборлолтын үйл ажиллагаанаас болон тээврийн хэрэгслийн дуу чимээнээс үүдэн мал амьтан үргэн дайжих,
- Хөрс, ургамалд амьдрагч бичил биетэн шавжууд устах,
- Олборлолт хийх, хөрс хуулах, овоолго үүсгэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэрэг үйл ажиллагаанд өртсөн талбайн амьтны аймаг, ялангуяа мэрэгчид, шавж, мөлхөгчид устаж үгүй болж тэдгээрийн амьдрах орчин байхгүй болох,
- Уурхайн ухаш хоосон орон зайд мал, амьтан унаж, бэртэх.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ:

- Олборлолт хийсэн талбайг тухай бүрд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж амьтны аймгийн эргэн суурьшиж амьдрах хугацааг богиносгох,
- Шаардлагагүй нүх, суваг шуудууг булж тэгшлэн амьтны явах замыг чөлөөтэй болгох,
- Шаардлагагүй нүх, суваг шуудууг хашиж хамгаалан амьтан унаж бэртэхээс хамгаалах,
- Уурхайн ажилчид нь ан, амьтан буй газарт анхааралтай хандан үйл ажиллагаагаа явуулах ба тэдгээрийн амьдрах нөхцөлийг алдагдуулахгүй байх,
- Уурхайн талбайд амьтан орж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд дайруулж, хорогдохоос сэргийлж, байнгын хараа хяналт тавих, хашаа хайс барих.
- Хууль бус ан агнуур хийхгүй байх.

3.5. Нийгэм эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн шугам сүлжээний гэмтэл, гал усны гэнэтийн аюул учирч болзошгүй. Үйл ажиллагааны явцдаа техникийн аюулгүй байдал алдагдах, гэнэтийн осол гарснаас ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх аюул үүсэх,
- Уурхайн ажлын үед машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй,
- Ажилчид хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллаагүйгээс үүсэх нөлөөлөл,
- Ажлын байрны тоо нэмэгдсэнээр нийгэм эдийн засгийн хөгжилд хэмжээний эерэг нөлөөлөл үзүүлнэ.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ:

- Ажилчдыг ажилд авахын өмнө эрүүл мэндийн үзлэгт оруулж, тэдний тухайн үеийн эрүүл мэндийн байдал, болзошгүй эрсдэлийн хүчин зүйл зэргийг тогтоох,
- Жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах,
- Ажилчдыг хөдөлмөр, эрүүл мэндийн хамгаалал, аюулгүй ажиллагааны хөтөлбөр сургалтад хамруулах,
- Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллах,

- Ажилчдыг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, түүнд бэлтгэлтэй байлгах үүднээс галын иж бүрэн багаж хэрэгсэл бэлтгэж, түүнийг эзэмших, болзошгүй аюул ослын үед ажиллах сургалтыг мэргэжлийн байгууллага хамтран явуулах,
- Уурхайн удирдлага орон нутгийн удирдлагатай нягт хамтран ажиллах, орон нутгаас ажилчдыг ажилд авч ажиллуулах.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. Талбайн физик газар Газрын гадарга, хөрс, ургамлын бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөл-ийн хамрах хүрээ	Зардал /төгрөг/ 2026 он	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын орчин						
1	-Уурхайн түүхий эдийн тээвэрлэлт, буулгалт, хадгалах зэргээс тоосжилт үүсэх гол сөрөг нөлөөлөл, - Техник тоног төхөөрөмж, хүнд машин механизм,	Зам талбайд тоосжилт дарах технологийн арга хэмжээ авах. Тоос баригч, барьцалдуулах бодис зам талбайд цацаж замыг барьцалдуулах даг-таршуулах, тоосжилт дарах зэрэг аргуудаас ашиглаж тоосжилтыг бууруулах.	Тээвэрлэлт-ийн зам талбай, овоолго.		Тогтмол	- MNS 3384-1982. Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавигдах ерөнхий шаардлага, - MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага,

2	тээврийн хэрэгслийн яндаанаас хаягдах бодисоор агаар бохирдох гол сөрөг нөлөөлөл, - Дуу чимээнээс төслийн талбай орчимд дуу чимээний бохирдол үүсэх гол сөрөг нөлөөлөл	Тээврийн хэрэгслийн орчны агаарт ялгаруулах ялгаралтыг багасгах үүднээс тэдгээр тээврийн хэрэгсэлд оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийх, техникийн үзлэгт оруулах.	Тээврийн хэрэг-сэл	560,000	1 удаа	- MNS0017-2-11:1988. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага , - Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, - MNS 5014:2009. Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилд зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга. - MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ хэвийн норм, түвшний хэмжээ
3		Олборлолтын үед дуу чимээний нөлөөллийг аль болох бага хэмжээнд байлгах, шөнийн цагаар уурхайн үйл ажиллагааг явуулахгүй байх.	Уурхайн талбайд	-	Тогтмол	
Хөрсөн бүрхэвч						

1	- Уурхайн үйл ажиллагаагаар Хөрсний элэгдэл эвдрэл үүснэ. -Хүнд даацын машин механизмын техникийн шатах тослох материал асгарах, алдагдах зэргээр хөрсөн бүрхэвчид бохирдол үүсгэх болзошгүй сөрөг нөлөөлөл, -Хатуу хог хаягдал ил задгай хаясnаас орчны хөрсөн бүрхэвчид химийн болон нянгийн бохирдол үүсгэх болзошгүй сөрөг нөлөөлөл	Шимт хөрсний овоолгыг салхинд тархахаас сэргийлж хамгаалах, ургамалжуулах, стандартыг дагуу хадгалах	Шимт хөрсний овоолго	-	2027-2029 онуудад	MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 4006:1987 Хөрс. MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага, -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох, -MNS 5914:2008 Уул уурхайн үйлдвэрлэлд өртөн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх техникийн шаардлага, -MNS 5918:2023 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага, -MNS 5916:2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
2		Тээврийн хэрэгслийг тогтсон нэг замын маршрутаар явуулах, замын тэмдэг тэмдэглэгээг байршуулах.	Уурхайн тээвэрлэлт-ийн зам	800,000	2026-2028 онуудад	
3		Тээврийн хэрэгслийн Хөдөлгүүрээс гарах ШТМ саармагжуулах арга хэмжээ авах, бохирдсон хөрсийг тухай бүр хуулж цэвэрлэж цэвэр хөрсөөр хучих, засвар үйлчилгээг хатуу хучилттай талбайд хийх.	Засвар үйлчилгээ хийх талбай	-	2026-2028 онуудад	
4		Уурхайн талбайд хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, уурхайн орчны цэвэрлэгээг тогтмол хийх	Хог хаягдал		Тогтмол	
Усны нөөц, чанар						
1	-Гүний худгийн усны хомсдол үүсэх,	Зөөврийн ундны усыг зориулалтын саванд нөөцлөх	Усны зориулалтын сав	100,000	2026-2027 онуудад	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, -Ус ашигласны төлбөр (2009 оны 351-р тогтоол),

2	-Шатах тослох материал хур тунадас болон үерийн усаар угаагдан хөрсний бага гүний усыг бохирдуулах, -Унд ахуйд хэрэглэх усыг ундны усны стандартад нийцүүлэх. -Ахуйн бохир ус алдагдаж гүний усанд нөлөөлөх	Байгалийн нөөц Ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу сав газрын захиргаатай ус ашигласны гэрээ байгуулан төлбөрийг тогтмол төлөх.	Ус ашиглах гэрээ, усны төлбөр	Тухайн жилийн усны хэрэглээнээс хамаарна	Жил бүр	-MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг Боловсруулах, хадгалах зөвлөмж, -MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт -MNS 3342:1982 Усан мандал. Газар доорх усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага.
3		Үерийн уснаас хамгаалах далан хаалт байгуулах.	Уурхай орчим	-	2027-2028 онуудад	
4		Хур борооны усыг хуримтлуулан тоосжилт дарах усалгаанд ашиглах	Ус хуримтлуулах	-	Тогтмол	
Ургамлын нөмрөг						
1	-Уурхайн ашиглалтын болон тээвэрлэлтийн үед ургамлын нөмрөг талхагдалд орох.	Уурхайн ашиглалтын явцад талхлагдсан талбайн ургамлын бүрхэвчийн нөхөн сэргээх боломжтой талбайг олборлолтын дараа зүлэгжүүлэх, ногоон байгууламж бий болгох	Уурхайн талбай	Нөхөн сэргээлтийн төлөвлөлтөд тусгагдсан	6 дахь жилээс	-Ургамал хамгааллын тухай хууль, газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2023,
2		Олон салаа зам үүсэхээс урьдчилан сэргийлж тээврийн хяналт маршрутыг нарийн төлөвлөх, уурхайн эдэлбэр газрын хил хязгаарыг тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах	Замын тэмдэг тэмдэглэгээ	Хөрсөн бүрхэвч-ийн төлөвлөгөөнд тусгагдсан	Тогтмол	
Амьтан						
1	-Уурхай ашиглалтын явцад, хүнд даацын машин техникийн хөл хөдөлгөөн, дуу чимээний	Их дуу чимээтэй машин техникт дуу чимээг намсгах арга хэмжээг авах	Дуу чимээ	-	Тогтмол	-Амьтны тухай хууль, -MNS 12.1.016-88, Хэт

2	нөлөөллөөр зэрлэг амьтад, шувууд үргэж дайжих, бэлчээрийн талбай хумигдах. -Уурхайн ашиглалтын явцад зэрлэг ан амьтад болон малчдын малын нүүдэллэх замд нөлөөлөх	Уурхайн эдэлбэр газарт мал, ан амьтан орохоос сэргийлэх арга хэмжээ авах, хамгаалалтын Хашаа бий болгох	Уурхайн талбай	1,000,000	2027 онд 2029 онд сайжруулах	өндөр дуу, аюулгүй ажиллагаа ний ерөнхий шаардлага, - MNS 5003 : 2000, ХАБЭА. Шуугианыг хэмжихэд тавигдах ерөнхий
Нийт дүн /төгрөг				**2,460,000**		

5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө Уурхайн олборлолтоор 7 жилийн хугацаанд нийт 12.5 га албай эвдрэлд өртөнө. Уурхайн нөхөн сэргээлтийг ашиглалтын сүүлийн жилүүдэд буюу 6-7 дахь жилээс хийхээр ТЭЗҮ-д төлөвлөсөн байна.

5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгааллын зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал /төгрөг/ 2026 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Орон нутгийн захиргаанаас санал авсны үндсэн дээр дүйцүүлэн хамгаалах ажлыг төлөвлөх.	Тогтоосон газар нутагт	-	Жил бүр	-Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, -Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, журам, стандартын дагуу
2	Хууль бус олборлолтод өртсөн талбайд нөхөн сэргээлт хийх.	Орон нутгаас санал авах	Дотоод төлөвлөл-төөр	Жил бүр	
3	Орон нутагт Биотехникийн арга хэмжээ авах Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх, орон нутгийн хамгаалалтад авсан нутагт байрших амьтдад өвс тэжээл тавьж өгөх	Орон нутгаас санал авах	3,300,000	Жил бүр	
4	Ховор амьтдын нүүдлийн замыг саадгүй болгох, зэрлэг амьтдын хяналт хийх (камер, судалгаа)	Тогтоосон газар нутагт	3,000,000	Жил бүр	
	Нийт дүн /төгрөг /		**6,300,000**		

5.4. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөө

Хүснэгт 4. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд

№	Дүйцүүлэн хамгааллын зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Модны төрөл	Тоо хэмжээ	Зардал /төгрөг / 2026 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримт-лах стандарт, аргачлал
1	“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тогтоосон газарт ойжуулалт хийх, ногоон байгууламж бий болгох	Орон нутгаас тогтоосон газарт мод бут тарих	Хайлаас, улиас	Жилд 1000 ш мод тарих	5,500,000	Жил бүр	“Тэрбум мод” үндэсний хөтөлбөр улсын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, журам, стандартын дагуу
	Нийт / төгрөг /				**5,500,000**		

5.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн талбай нь суурьшлын бүстэй ойр боловч уурхайн талбайн ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ хийгдэхгүй.

5.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн талбайн ойролцоо археологи, палеонтологийн олдвор одоогийн байдлаар илрээгүй. Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

5.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээ-ний цар, хэмжээ	Зардал /төгрөг/ 2026 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	- Болзошгүй	Байгаль орчныг хамгаалах, осол, эрсдэлээс хамгаалах, галын аюулаас сэрэмжлүүлэх зэрэг зааварчилгааг байнга өгч байх	Ажилчид	-	Тогтмол	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17),

2	аюул осол аваар гарах, -Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл үүсэх, - Техникийн эвдрэл гэмтэл үүсэх, -Галын аюул үүсэх.	Уурхайн ашиглалтын үед ХАБ-ын мэргэжилтнийг уурхайн талбайд байнга ажиллуулж заавар зөвлөмжийг өдөр бүр өгч ХАБ-ын хэрэгжилтэд өдөр дутам хяналт тавьж ажиллах шаардлагатай.	Ажилчид	-	Тогтмол	-MNS6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр томьёо, тодорхойлолт, ерөнхий анги, -MNS 5002 2000: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй -Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага, -MNS 12.4. 005 – 1985: Хөдөлмөр хамгаалал. Шуугианаас хамгаалах хэрэгсэл ба аргууд.
3		Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмж	-	Тогтмол	
4		Аваар устгах төлөвлөгөөг жил бүр батлуулж түүний дагуу ажиллах, ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч байх	Уурхайн удирдлага	-	Тогтмол	
5		Ажиллагсдыг хөдөлмөр хамгаалах хувцас хэрэгслээр бүрэн хангах	Уурхайн удирдлага	4,300,000	Тогтмол	
6		Хөдөлмөр хамгааллын тухай сургалтыг зохион байгуулах	Уурхайн удирдлага	500,000	Жил бүр	
7		Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг зохих газруудад байрлуулах, бүрэн бүтэн байдлыг тогтмол хангах, аюулын гарцын (хэрэв тодорхой биш бол, жишээ нь ганц хаалгатай бол) байрлалыг заасан самбар хадах, галын дохиолол, гал унтраах зөвшөөрөгдсөн тэмдэг тавьсан байх.	Уурхайн удирдлага	1,000,000	Жил бүр Нэмэх, сайжруулах	
	Нийт / төгрөг /			**5,800,000**		

5.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 6. Хог хаягдлын менежмент төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хог хаягдлын код	Аюул-ын зэрэг лэл	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Зардал /төгрөг/ 2026 он	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах стандарт, аргачлал
1	Ахуйн хог хаягдлыг зайлуулаагүйгээс үүсэх бохирдол	Ахуйн хог хаягдал	Т 01 Т0301	-	Энгийн хог хаягдлаа ангилан ялгах, хог хаягдлын цэгийг стандарт шаардлагын дагуу байгуулах, шаардлага хангасан ангилан ялгах хогийн сав байршуулах	1,000,000	Уурхайн үйл ажиллагаа эхлэх үед	-Хог хаягдлын тухай хууль /2017.05.12/, -MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага, - Ариун цэврийн тухай хууль, -Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль.
2				-	Ахуйн хог хаягдлыг тусгай нэг цэгт төвлөрүүлэх, салхинд тархахаас сэргийлж хашаажуулах	-	2027 онд	

3				-	Ахуйн хатуу хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулж, гэрээний дагуу тогтмол зайлуулах	350,000	Жил бүр	
4		Цаасан болон кардонон сав баглаа боодол	15 01 01	-	Цуглуулж хаягдал боловсруулах картон цаас авдаг үйлдвэрт өгөх.	-	Жил бүр	
5		Хуванцар сав баглаа боодол	15 01 02	-	Тусгайлан заасан газарт цуглуулж, хоёрдогч түхий эдийн цэгт тушаах	-	Жил бүр	
6	Аюултай хог хаягдлаар орчин бохирдох	Шилэн сав	15 01 07	-		-	Жил бүр	
7		Түлшний тос, дизель	13 0 501*	A	Ашигласан шатах тослох материалын үлдэгдлийг зориулалтын саванд цуглуулж	-	Жил бүр	
8		Бензин	13 0 502*	A		-	Жил бүр	
9		Бусад түлш (холимог түлш орно)	13 0 503*		аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлэх			

10		Хөдөлгүүрийн гидро тос, Масло, Моторын хөдөлгүүр-ийн хайрцгийн тос	13 02 05*		Зориулалтын тагтай саванд ангилан ялгаж хадгалж, дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлэх	-	Жил бүр	
11		Ашиглалтаас гарсан дугуй	16 01 01		Уурхайн талбайд контейнерт хадгалж, тээвэрлүүлэх	-	Жил бүр	
12		Ашиглалтаас гарсан автомашин	16 01 02*		Уурхайн талбайгаас өөр газар луу шилжүүлэх, холдуулах.	-	Жил бүр	
13		Тосны шүүр	16 01 04*		Тусгай зориулалтын хуванцар хаягдлын саванд хуримтлуулж дахин боловсруулах үйлдвэр лүү Тээвэрлүүлэх хаягдлын саванд хуримтлуулж дахин боловсруулах	-	Жил бүр	
14		Тоормос-ны шингэн	16 01 10*				Жил бүр	

					үйлдвэр лүү тээвэрлүүлэх			
15		Хар тугалгатай батарей аккумулят орын хаягдал	16 06 06*	А	Уурхайн талбайд контейнерт хадгалж, дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлэх		Жил бүр	
16		Тосны сав хуванцар төмөр	17 02 04* 15 01 10*	А	40 тонны контейнерт хадгалж, дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлэх		Жил бүр	
17		Ажилчдын ахуйн бохир усыг ил задгай асгахгүй байх	Т 0305		Бохир ус		Тогтмол	
Нийт дүн /төгрөг/						***1,350,000***		

5.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “СУММУС” ХХК-иас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж -ийн тоо	Нэгжийн зардал	Зардал /төгрөг/ 2026 он	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын орчин								
1	Агаарын тоосны (TSP, PM_{10}, $PM_{2.5}$) шинжилгээ	-Уурхай орчмоос, -Овоолго орчмоос -Кемп орчмоос	Улиралд 1 удаа	3 цэг (3 үзүүлэлт)	Агаарын шинжээч-ийн томилолт тохиролцсоно ор. Агаарын сорьц дээж- 1 үзүүлэлт- 45,000	525,000	Агаарын шинжээч, итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ өгөх.	- “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016, -MNS 3383:1982. Агаар мандал. Бохирдуулагч ийн эх үүсвэрийг тодорхойлох - MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий Шаардлага -MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга.
2	Агаарын бохирдлын цэгэн шинжилгээ: Нүүрстөрөгч ийн исэл (CO), Азотын исэл (NO_2), Хүхрийн давхар исэл (SO_2-),	-Уурхай орчмоос, -Кемп орчмоос	Жилд 1 удаа	2 цэг (3 үзүүлэлт)		370,000		
Хөрсөн бүрхэвч								
1	**Хөрсний агрохимийн шинжилгээ:** Хөрсний үе давхаргын зузаан (см),	- Уурхайн талбай орчмоос,	Жилд 2	3 цэг	Агрохими	168,000	Хөрсний	- MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүд ийн нийт хэмжээг тодорхойлох

	ялзмаг %, pH, давсжилт, чийгшилт, Физик шинж чанар, органик бодис, нийт азот, карбонат, Ca, Mg, P_2O_5, K_2O, хөрсөн дэх нефтийн бүтээгдэхүүн.	- Овоолго орчмоос, -Кемп орчмоос.	удаа	сонгох	шинжилгээ 28,000		итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ өгөх.	арга, -MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох арга, -MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага, -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, магани, никель, цайрыг тодорхойлох
2	**Хөрсний хүнд металлын шинжилгээ:** Кадьми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	-Уурхай орчмоос, - Тээвэрлэлтийн замаас	Жилд 2 удаа	2 цэг сонгох	Хүнд металлын шинжил-гээ- 28,000	112,000		
Усан орчин								
1	Усан дахь эрдэс бодисууд, химийн найрлага: (Анионууд: Cl^-, SO_4^-, NO_2^-, NO_3^- $CO3^{--}$, HCO_3 - Катионууд: $Na^{++}K^+$, Ca^{++},Mg++,	Унд ахуйн уснаас	Жилд 2 удаа	1 цэг	Усны шинжилгээ, Ерөнхий 50,000	180,000	Усны итгэмжлэгдсэн лабораторид	-MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага, -MNS 13.060.50 Усны чанарын стандарт, -MNS 0900 : 2005

	NH4+, Fe++, Fe+++, pH, EC, TDS, Физик чанар: тунгалаг, үнэр, тунадас, өнгө, амт) Ундны усны стандарт (MNS 900:2010)-ын шаардлагад нийцэж буй эсэхийг хянах, бактериологийн шинжилгээ хийлгэх				Хүнд металл, бактерлоги 90,000			Ундны ус. Эрүүл Усны түвшин (газрын гадаргаас ахуйн шаардлага, түүнд тавих хяналт.
Нийт /төгрөг/						**1,355,000**		

5.10. Тухайн жилийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа				Хариуцсан албан тушаал	Тайлбар
		Зардал /төгрөг/ 2026 он	2026-2030 он				
			5-6-р сар	7-8-р сар	9-10-р сар		
1	Байгаль орчныг хамгаалах сургалтыг ажилчдад зохион байгуулах	500,000		+		Уурхайн удирдлага	Ажилчдад байгаль орчныг хамгаалах талаар мэдлэг олгох.
2	Ажиллагсдыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	1,360,000		+		Уурхайн удирдлага	Ажилчдын эрүүл мэндэд анхаарал хандуулах.
3	Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх	-		+		Уурхайн удирдлага	2 жил тутамд байгаль орчны аудит хийлгэх
4	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээний дагуу хамтран ажиллах	Орон нутагтай тохиролцох	+	+		Уурхайн удирдлага	Орон нутагтай нягт хамтран ажиллах
5	Газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгаа хийлгэх	Мэргэжлийн байгууллагатай тохиролцох.				Уурхайн удирдлага	Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаа 5 жилд 1 удаа хийлгэх
Нийт дүн /төгрөг/		***1,860,000***					

5.11. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах

Хүснэгт 9. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

д/д	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Тайлагнах зардал, төгрөг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Аймгийн байгаль орчны газарт	Уулзалт, санал асуулга, тайлан	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах	11-р сарын 01-ны дотор	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн удирдлага,	Уурхайд, Аймгийн БОГ-т

		хэлбэрээр				байгаль орчны мэргэжилтэн	
2	БОУАӨЯ-ны ХБОБНУГ	Тайлан хэлбэрээр	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, орон нутгийн дүгнэлт	12-р сарын 30-ны дотор			БОУАЯ-ны ХБОБНУГ-т
	Нийт				**-**		

5.12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	**Хэрэгжүүлэх арга хэмжээ**	**Зардал /төгрөг/ 2026 он**
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,460,000
2	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	6,300,000
3	Тэрбум модны төлөвлөгөө	5,500,000
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	5,800,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,350,000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,355,000
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1,860,000
10	БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	-
Нийт зардал /төгрөгөөр/		**24,625,000**